



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Монголын Либерал Ардчилсан намын
дүрмийн өөрчлөлтийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын Либерал Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн дарга гэх Г.Анхбаяраас гаргасан “Дүрмийн нэмэлт, өөрчлөлт бүртгүүлэх тухай” өргөдлийг шүүгч Ц.Цогтын илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Монголын Либерал Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн дарга гэх Г.Анхбаяраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр “2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Монголын Либерал Ардчилсан намаас намын дүрэмд, нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт Монгол Улсын дээд шүүхэд хүргүүлсэн боловч 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 23 тоот тогтоолоор татгалзсан шийдвэр хүлээн авсан.

Тус шийдвэрийг хүлээн аваад манай намын Ерөнхий зөвлөл 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хуралдан намын Бүгд хурлыг хуралдуулах шийдвэр гарсан. 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Бүгд хурал хуралдаж, Дээд шүүхээс ирүүлсэн шийдвэрийн тодорхойгүй нөхцөлийг хангасан шийдвэрүүдийг хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж хүргүүллээ.

Иймд Монголын Либерал Ардчилсан намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэж өгнө үү” гэсэн агуулгатай өргөдлийг холбогдох материалын хамт Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

2. Дээрх өргөдөлд хавсаргасан тайлбартаа “2008 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Монголын Либерал Ардчилсан намын Их чуулганаар Бүгд хуралд Их чуулганы эрхүүдийг шилжүүлсэн тогтоол батлагдсан байдаг.

- Намын хөтөлбөр, дүрмийг хэлэлцэн баталж, тэдгээрт өөрчлөлт оруулах
- Намын Бүгд хурал, хяналтын хорооны тайланг хэлэлцэх
- Намын Бүгд хурлын гишүүдийг сонгож байгуулах, батламжлах
- Намын даргыг сонгох

Эдгээр эрхүүд нь Бүгд хуралд түр хугацаагаар буюу дараагийн Их чуулган хуралдах хүртэл олгогдсон. Улс төрийн намын тухай хуулийн 13.4-д “Намын Их

Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж заасан байдаг бөгөөд Монголын Либерал Ардчилсан намын төлөөллийн төв байгууллага нь Бүгд хурал юм. Иймд 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Бүгд хурлаар Бүгд хурлын гишүүд баталгаажуулсан болно. Энэ хугацаанд намын Их чуулган хуралдаагүй болно.

2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Монголын Либерал Ардчилсан намын Хяналтын хорооны дүгнэлт гарсан. Уг дүгнэлтэд Бүгд хурлын дараагийн гишүүд сонгогдсоноор өмнөх гишүүдийн эрх дуусгавар болно гэж дүгнэсэн. Мөн Улс төрийн намын тухай хуулийн 13.9-д намын эрх бүхий байгууллага намын дотоод асуудлыг хянан шийдвэрлэнэ гэж заасан байдаг. Иймд Бүгд хурлаас сонгогдсон Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Анхбаяр нь намыг төлөөлөн өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхтэй гэж үзэж байна. 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурлаас 007 тоот тогтоолоор Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Анхбаярт намын өдөр тутмын бүх асуудлыг хариуцан, хувь хүн, аж ахуй нэгж, байгууллага, төрийн байгууллагууд болон шүүхэд Монголын Либерал Ардчилсан намын даргыг төлөөлөн бүрэн эрхийг хэрэгжүүлж, ажиллах итгэмжлэлийг олгосон болно” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурлын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 005 дугаар тогтоолоор тус намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хууль болон намын дүрэмдээ нийцсэн байх тул дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээр шийдвэрлэв.

1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “намын дүрмийн 3.4-т заасны дагуу 2008 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр сонгогдсон Бүгд хурлын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр дуусгавар болсон, ... 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр хуралдсан Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурлын “Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох тухай” 005, “Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 006 дугаартай тогтоолуудыг эрх бүхий этгээдээс гаргасан гэж үзэх боломжгүй” гэсэн үндэслэлээр өргөдлийг хангахаас татгалзжээ.

2.Монголын Либерал Ардчилсан намаас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 11 дүгээр албан бичгээр дахин “Дүрмийн нэмэлт, өөрчлөлт бүртгүүлэх тухай” өргөдөл гаргажээ.

2.1.Тус өргөдөлд Монголын Либерал Ардчилсан намын 2008 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Их чуулганы зарим эрхийг шилжүүлэх тухай” 08/006 дугаартай тус намын Их чуулганаас дүрмийн “3.7.8.1.Намын хөтөлбөр, дүрмийг хэлэлцэн баталж тэдгээрт өөрчлөлт оруулна., 3.7.8.2.Намын бүгд хурал, хяналтын хорооны тайланг хэлэлцэнэ., 3.7.8.3.Намын Их чуулган Намын бүгд хурлыг сонгож байгуулна. Бүгд хурал намын байгууллагуудаас сонгогдсон 81 гишүүнтэй байна., 3.7.8.5.Намын даргыг сонгоно.” зэрэг бүрэн эрхийг түр Бүгд хуралд шилжүүлсэн тогтоолыг ирүүлсэн.

2.2.Монголын Либерал Ардчилсан намын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Бүгд хурлыг намын дүрэмд “3.7.9.9.Бүгд хурлыг шаардлагатай үед Ерөнхий зөвлөл зарлан хуралдуулна ...” гэж заасны дагуу зарлан хуралдуулжээ.

2.3.Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурлын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 004 дүгээр тогтоолоор тус намын Их чуулганы 2008 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 08/006 дугаар тогтоолоор түр шилжүүлсэн эрхийн дагуу

намын Бүгд хурлын гишүүдийн бүрэн эрхийг улираан батламжилж, улмаар 005 дугаар тогтоолоор тус намын дүрэмд нэмэлт оруулахаар шийдвэрлэжээ.

2.4.Тус намаас 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн өргөдөлд нэмж ирүүлсэн баримт болох Ээлжит бус Их чуулганы 2008 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 08/005 дугаар тогтоолоор сонгогдсон Бүгд хурлын 70 гишүүнээс 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Бүгд хурлаар 60 гишүүний бүрэн эрхийг улираан батламжилсан байна.

3.Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж, мөн тус намын дүрмийн “3.7.9.7.Шаардлагатай гэж үзвэл намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно” гэж заажээ.

3.1.Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д “намын дүрэм, хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан” тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана.

3.2. Энэ тогтоолын 2.4-т заасан Ээлжит бус Их чуулганаас сонгогдсон Бүгд хурлын гишүүд Бүгд хурлын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 005 дугаар тогтоолоор намын дүрмийн Бүгд хурлын талаар зохицуулсан 3.7.9 дэх хэсэгт:

-3.7.9.11-д намын төлөөллийн төв байгууллага буюу хуульд зааснаар намын эрх бүхий байгууллага нь Бүгд хурал мөн.

-3.7.9.12-д намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг намын эрх бүхий байгууллага буюу Бүгд хурал шийдвэрлэнэ.

-3.7.9.13-д Бүгд хурлаас намын Дотоод Сонгуулийн хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

-3.7.9.14-д Бүгд хурлаас намын даргыг

А.Сонгуулийн үр дүнгээр огцруулах, сонгох

Б.Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх, сонгох

-3.7.9.15-д Бүгд хурлаас намын дүрмийн дагалдах журмуудыг батална гэх заалтуудыг нэмж, өөрчлөхөөр шийдвэрлэсэн. Эдгээр нэмэлт нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан хуульд харшилсан гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

4.Иймд Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурлын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 005 дугаар тогтоолоор тус намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тус намын дүрмийн 3.7.9.7 дахь заалт болон Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т нийцсэн байх тул нийт шүүгчийн хуралдаанаас улсын бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасныг баримтлан Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурлын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 005 дугаар тогтоолоор баталсан Монголын Либерал Ардчилсан намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсүгэй.

2.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ